



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь:

“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Нью Тур Сафарис” ХХК-ийн хооронд байгуулсан түрээсийн гэрээний тухай


ТЭМДЭГЛЭСЭН нь:

“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Нью Тур Сафарис” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд байгуулсан түрээсийн гэрээг дахин хянаж, түрээсийн талбай, үнийг шинэчлэн тогтоож, түрээсийн төлбөрийг түрээслэгч талаас нөхөн төлүүлэх хэрэгтэй. Түрээсийн төлбөр тооцох төрийн өмчийн нийт талбайг 2059 м.кв-аар тооцож, кино театр болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад ногдох талбайг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “бусад” ангилалд, кино театраас бусад худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлж буй талбайг мөн жишгийн 1 дэх хэсэг “худалдаа, үйлчилгээ” ангилалд тус тус хамааруулахыг дэмжсэн.

Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах, түрээсийн гэрээний хугацааг сунгах зөвшөөрлийн тухай 751 дүгээр тогтоолыг эргэн харж, түрээслэгч талын хийсэн хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа, төрд хүлээлгэж өгөх хугацааг тогтоох шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах, түрээсийн гэрээний хугацааг сунгах зөвшөөрлийн тухай 751 дүгээр тогтоолоор баталсан “Нью Тур Сафарис” ХХК-ийн хийсэн хөрөнгө оруулалтын нийт дүн 5,181,587,800.00 (таван тэрбум нэг зуун наян нэгэн сая таван зуун наян долоон мянга найман зуун) төгрөгөөс хөдлөх хөрөнгийн дүн 2,064,705,376.00 (хоёр тэрбум жаран дөрвөн сая долоон зуун таван мянга гурван зуун далан зургаан) төгрөгийг хасч тооцон, түрээслэгч талтай хэлцэл хийж баталгаажуулахыг “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Содномдамбад даалгав” гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

000242